# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 15 өдөр Дугаар А/564 Номгон

"Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээнийг
зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Засгийн газрын 2023 оны "Эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлэх тухай" 322 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайд нарын хамтарсан 2024-2027 онд хэрэгжүүлэх "Эрүүл шүд" арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2024 оны А/27, А/25 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Эрүүл шүд" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн газар, Боловсролын газартай хамтран "Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсугай.

2.Шагнал урамшуулалд зарцуулагдах зардлын тооцоог нэгдүгээр хавсралтаар батalсугай.

3.Тэмцээний бэлтгэл ажлыг хангаж, үр дүнтэй зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), Боловсролын газар (Ж.Алтанцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тэмцээний үйл ажиллагаанд шаардлагатай 1.050.000 (Нэг сая тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс санхүүжүүлэхийг Засаг даргын тамгын газар (Д.Энхжаргал)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

624211435

Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1/564 дүгээр захирамжийн хавсралт

# ШҮД УГААЛТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

2024 оны 10 дугаар сарын 02 Номгон

| № | Шагналын төрөл | Шалгарсан сургууль | Мөнгөн дүн |
|---|---|---|---|
| 1 | Шилдэг баг тэргүүн байр | Номгон сургуулийн “STARS” баг | 315.000 |
| 2 | Шилдэг баг дэд байр | Эрдэм сургуулийн “Эрдмийн хөтөч” баг | 210.000 |
| 3 | Шилдэг баг гутгаар байр | 5-р сургуулийн “Сүүн шүдхэн” баг | 105.000 |
| 4 | Хувцас жигдрэлтэй сургууль | Гэгээн сумади сургууль | 210.000 |
| 5 | Шилдэг оролцогч 1 | Номундалай сургуулийн “Эрүүл шүд” багийн сурагч Д.Мөнхзаяа | 105.000 |
| 6 | Шилдэг оролцогч 2 | Эрдэм сургуулийн “Ирээдүйн ээзд” багийн сурагч М.Хишигдэлгэр | 105.000 |
| **Нийт** | | | **1.050.000** |

________________oOo________________